

Ерөнхий мэргэжлийн эмч

Тестийн зөв хариулт-1

1-E, 2-B, 3-B, 4-A, 5-D, 6-C, 7-D, 8-B, 9-B, 10-A, 11-D, 12-C, 13-C, 14-A, 15-B, 16-D, 17-E, 18-A, 19-D, 20-C, 21-E, 22-C, 23-A, 24-D, 25-A, 26-A, 27-E, 28-D, 29-B, 30-A, 31-A, 32-D, 33-A, 34-C, 35-C, 36-D, 37-A, 38-A, 39-B, 40-C, 41-B, 42-C, 43-E, 44-B, 45-B, 46-D, 47-C, 48-C, 49-A, 50-C, 51-B, 52-D, 53-D, 54-A, 55-D, 56-B, 57-E, 58-A, 59-A, 60-A, 61-B, 62-B, 63-B, 64-C, 65-B, 66-A, 67-E, 68-A, 69-B, 70-E, 71-D, 72-A, 73-C, 74-A, 75-B, 76-D, 77-A, 78-B, 79-A, 80-D, 81-A, 82-A, 83-C, 84-D, 85-B, 86-C, 87-B, 88-D, 89-B, 90-A, 91-D, 92-A, 93-C, 94-C, 95-C, 96-D, 97-B, 98-E, 99-C, 100-A,

Тестийн түлхүүр

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
- 1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол (B.)
- 2 ба 4 дүгээр хариултууд зөв бол (C.)
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
- Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

- Зөв, Зөв, Зөв (A.)
- Зөв, Зөв, Буруу (B.)
- Зөв, Буруу, Буруу (C.)
- Буруу, Зөв, Буруу (D.)
- Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Бүсэлхий сээр нурууны нугалмын шахагдсан хугарлыг сэргээн засах эмчилгээ хийх.

A. 2-10 хоногт эрүүл ахуйн ерөнхий дасгал /амьсгал/ дээд, доод мөчийг бүрэн биш хэмжээгээр 10 илүүгүй хөдөлгөнө

B. 10-20 хоногийн дараа хэвлий, нурууны булчин бэхжүүлэх, дээд мөчний үеэр бүрэн хэмжээгээр 20 удаа хөдөлгөн хоногийн сүүлчээр хэвлийгээр эргэнэ

C. 20-60 хоногт дасгалыг 10-15 удаа давтаж үеэр 30-аас дээш хөдөлгөн хийнэ

D. 60-80 хоногт өвчтөнг босоход бэлтгэж 10-20 минутаар суулгана.

E. Физик эмчилгээ хослоно

/2./ Цахилгаан гүйдэлд цохиулахад авах арга хэмжээ

а/ Зохиомол амьсгал хийх

б/ Шингэн ихээр сэлбэх

в/ Гүйдлээс салгах

г/ Кордиамин тарих

д/ Зүрхний гаднах иллэг

A. а, б, в

B. а, в, д

C. б, г, д

D. а, б, г

E. в, г, д

/3./ Монтеджийн хугарал-мултрал аль нь вэ?

A. Нэг гарт шуу яс мултарч, нөгөө гарт хугарал тохиолдоно

B. Шуу ясны толгой мултарч, богт чөмөг гандан хэсгийн дунд болон дээд/3 хугарал нэг гарт тохиолдоно

- C. Сарвуу мултарч, шуу, богт чөмөгт гандан хэсгийн дунд/3 түвшинд хугарна
 D. Тохойн үе мултарч, богт чөмөг гандан хэсгийн доод/3 түвшинд хугарна
 E. Тохой мултарч шуу ясны гандан хэсэг дунд/3 түвшинд хугарна
- /4./ Төрөлхийн мултралыг засах эвийн эмчилгээнд ямар хүндрэл гарч болох вэ?
 A. Үений толгой үхжих
 B. Суудлын мэдрэл саажих
 C. Түнхний үеэр хөдөлгөөнгүй болох
 D. Үеэр байнгын өвдөлттэй
 E. Үений үрэвсэл
- /5./ Хүнд хам гэмтэл мөчний хугаралд өвчин намдаах хэсгийн хориг хийх гол хүчин зүйл аль нь вэ?
 A. Артерийн даралтыг бууруулахгүй байх
 B. Биеийн температурыг бууруулах
 C. Удаан хугацаагаар өвчин намдаах үйлчлэлийг хангах
 D. Өвчин бүрэн намдаах нь эмнэл зүйн ажиглалтанд саад болохгүй байх
 E. Төвийн венийн даралтыг нэмэгдүүлэх
- /6./ Ясны уйланхай /киста/-н эмчилгээг сонгоно уу?
 A. Зөвхөн туяаны эмчилгээ
 B. Зөвхөн хатгалт хийж авах
 C. Эвийн эмчилгээ үр дүн өгөхгүй бол мэс заслын эмчилгээ
 D. зөвхөн мэс заслын эмчилгээ
 E. Зөвхөн химийн эмчилгээ
- /7./ Эгэмний яс голдуу аль төвшиндөө хугардаг вэ?
 A. дунд 1/3-ээр
 B. гадна 1/3-ээр
 C. дотор 1/3-ээр
 D. гадна дунд 1/3-ын уулзвараар
 E. Дунд дотор 1/3-ын уулзвараар
- /8./ Өвдөгний үеийг хиймлээр сольсны дараа эхний сард өвдөх хамгийн бага шалтгаан аль нь вэ?
 A. Халдвар
 B. Үрэлтээс хугарал үүсэх
 C. Протез зөв биш тавигдсанаас
 D. Зөөлөн эд хавчуулагдах
 E. Зөөлөн эдийн тэнцвэржилт муугаас тогтворгүй болох
- /9./ Эх барихын саажилт /дюшен эрба-хам шинж/ дээд мөчинд тэргүүлэх шинж тэмдэг аль нь вэ?
 A. Хуруу, сарвууны хөдөлгөөн байхгүй байна
 B. Мөр хавчсан, дотогш эргэлттэй байна
 C. Нэг талын саатай /төвийн гаралтай/
 D. Гар бүхэл дээ идэвхитэй хөдөлгөөнгүй
 E. Мөрний үеэр хөдөлгөөнтэй, хуруунууд хөдөлгөөнгүй
- /10./ Олье өвчний үед мэс заслын эмчилгээ хийх тохиромжтой нас
 A. Сургуулийн өмнөх
 B. Сургуулийн
 C. Бэлгийн боловсролын үед
 D. Насанд хүрсэн
 E. Аль ч насанд болно
- /11./ Хавирга голдуу аль шугамаар хугардаг вэ?
 A. L A A
 B. L M S

- C. L M C
- D. L A P
- E. LAM

/12./ Дунд чөмөгний хүзүүний хугарлын үед илрэх шинж тэмдэгийг нэрлэнэ үү.

- A. Вернеллын шинж
- B. Розер Нелатоны шугам өөрчлөх
- C. Өсгийн наалдах шинж
- D. Гуяа хавчих байрлалд байх
- E. Ларрегийн шинж

/13./ Түнхний үений деформирующая остеоартрозын эрт илрэх эмнэл зүйн шинж

- A. Түнхний үеэр өвдөнө
- B. Гуяны доод 1/3 хэсэг өвдөгний үеэр өвдөнө
- C. Хавчих байрлалд контрактура үүснэ
- D. Мөч богиносно.
- E. Үеэр хавдана

/14./ Хүзүүний мэдрэлийн сүлжээнд хориг хийх нь аль нь зөв бэ?

- A. m.Sterno-Cleido-mastoideus-ийн дунд, ар захаар
- B. m.Sterno-Cleido-mastoideus булчингийн дунд, урд захаар
- C. 2-р хүзүүний түвшинд
- D. Хэлэн доорхи ясны түвшинд
- E. Эгэмээс дээш 2 см түвшинд

/15./ Төрөлтийн үед хүүхдэд гарч болох хагд үеийн гэмтэл /эпифизолиз/ ямар мөчинд, аль түвшинд илүүтэй тохиолдож болох вэ?

- A. Атгаал чөмөгний эхлэх хэсэгт
- B. Атгаал чөмөгний төгсгөл хэсэгт
- C. Дунд чөмөгний эхлэх хэсэгт
- D. Дунд чөмөгний төгсгөл хэсэгт
- E. Шаант чөмөгний эхлэх хэсэгт

/16./ Түлэнхийн өвчтэй хүнийг үнэлэх үндсэн үзүүлэлтүүд

- а/ Түлэгдлийн талбай,
- б/ Зүрх судасны үйл ажиллагаа
- в/ Бөөрний үйл ажиллагаа
- г/ Түлэгдлийн гүн
- д/ Ухаан самуурах

- A. а, б, в
- B. б, в, г
- C. а, б, д
- D. а, в, г
- E. в, г, д

/17./ Шууны ясны толгой хүүхдийн хэдэн насанд бүрэн мултарч болох вэ?

- A. Нярай
- B. 1 хүртэл
- C. 1-3 нас
- D. 4-7 нас
- E. 5-12 нас

/18./ Мөчний олон хугарал, хам гэмтлийн эрт нас баралтын голлох шалтгаанд аль нь вэ?

- A. Цус алдалт
- B. Гавал тархины гэмтэл
- C. Амьдралын чухал эрхтэний гэмтэл
- D. Гэмтэл шок III, IV зэрэг

- Е. Тулгуур хөдөлгөөний эрхтэний гэмтэл
- /19./ Түнхний үений гажиг хөгжлийн хүүхдийн амьдралын эхний саруудад тэргүүлэх шинж тэмдэг юу вэ?
- А. Мөч богиносох
 - В. Арьсны нугалаас ижил биш
 - С. Дюшенатрендленбургийн шинж тэмдэг
 - Д. Алцайлт хязгаарлагдана
 - Е. Мөч гадагш эргэсэн байдалтай
- /20./ Гавал тархи нуруу нугасны үрэвсэл бүхий хүндэрсэн гэмтлийн үед антибиотик яаж сонгох вэ?
- А. Үрэвслийн үед пенициллиныг өндөр тунгаар хэрэглээд дараа нь бусад антибиотикийг сонгоно.
 - В. Өвчтөний асуумжаас өөрт нь тохирох антибиотикийг хэрэглэнэ
 - С. Цус ба хэсэг газрын үрэвслийн арчдаснаас авсан антибиотикийн мэдрэг чанарыг үндэслэнэ.
 - Д. Орчин үеийн өндөр хүчтэй антибиотикийг шууд хэрэглэнэ
 - Е. Бактериологийн шинжилгээг гартал
- /21./ Шаант чөмөгний гандан хэсгийн бага хүчээр үүсгэгдсэн хугаралд тамхи татдаг өвчтөнд аль нь ямар хамаатай вэ?
- А. Эдгэрэх явц нь 4 дахин удаан
 - В. Тамхи, татдаггүйд адилхан
 - С. Энэ хугарал нь тамхичинд 1.5 дахин илүү тохиолдож, 2 дахин илүү удаан бороолоно.
 - Д. Тамхичинд 4 дахин илүү тохиолдоно, эдгэрэлт адил
 - Е. 4 Дахин их тохиолдоно, эдгэрэлт удаашрана
- /22./ Яс түлэгдэх халууны хязгаарыг заана уу?
- А. 460С
 - В. 510С
 - С. 560С
 - Д. 610С
 - Е. 700С
- /23./ Гуяны төвшинд тайралтын дараа гуя хавчих хүчийг сулрахаас сэргийлж ямар арга хэмжээ авах вэ?
- А. Гуя хавчигч том булчинг, гуяыг хавчмал байрлалд гуяны гадна талд холбох /миодез/
 - В. 4 толгойт булчинг тахимны шөрмөстэй холбох болон гуя хавчих булчинг гуяны өргөн ханчиртай холбох
 - С. Протезийн аягыг гуя хавчмал байдалд тохируулах
 - Д. Хагалгааны өмнө гуя хавчих булчингийн дасгалыг идэвхитэй хийх
 - Е. Хагалгааны дараа гуя хавчих булчингийн дасгалыг идэвхитэй хийх
- /24./ Бүсэлхий мэдрэлийн сүлжээ ямар мэдрэлээс хэлбэржих вэ?
- А. Th12-L4
 - В. Th12-L5
 - С. L1-L4
 - Д. L1-L5
 - Е. Th9-10
- /25./ Сээр, бүсэлхий нурууны гэмтлийн механизмаар эмнэлзүйн ангилсан орчин үеийн бүх ангиллын суурь ангилал аль судлаачийнх вэ?
- А. Nicoll
 - В. Holdsworth
 - С. Mc Afee
 - Д. Kelly
 - Е. Whitesid

- /26./ Өвдөгний үений мултралд артериография шинжилгээ хийх үү.
- A. Артериография хийнэ
 - B. Мултралыг оруулсны дараа хийнэ.
 - C. КТГ хийнэ
 - D. Артериография хийхгүй
 - E. Өвдөгний үений рентген зураг эгц хажуугаас авна
- /27./ Атгаал ясны чөмөгт гандан хэсгийн хугарлын гол эмчилгээ аль нь вэ?
- A. Шахаж сунгах аппарат
 - B. Ясны чөмөгний голоор хадах мэс засал
 - C. Хугарлыг эвлүүлж гаднаас нь металл ялтасаар бэхлэх
 - D. Бариа засал, гөлтгөнөн боолт
 - E. Эвийн эмчилгээ
- /28./ Бүрхэвчийн дунд артери хаанаас гардаг вэ?
- A. Гүрээний дотор артериас
 - B. Нурууны артериас
 - C. Гүрээний гадна артериас
 - D. Дээд эрүүний артериас
 - E. Доод эрүүний артериас
- /29./ Шаант чөмөг, тахилзуур ясны хоорондох таславч (membrane) үндсэн үйл ажиллагаа аль нь вэ?
- A. Шаант чөмөг тахилзуурын доод түвшинд зай (diastasis) гарахаас урьдчилан сэргийлнэ.
 - B. Тахилзуурт ачаалал өгөхөд аргаш бөхийхөөс урьдчилан сэргийлнэ
 - C. Тахилзуурын бүлэг булчингууд холбоотойгоор ажиллахад хангалттай зай бариулна.
 - D. Тахилзуур болон арын өнгөц хайрцагуудыг (compartments) салгаснаар цусгүйдлийн хам шинжийг хязгаарлах ач холбогдолтой
 - E. Шаантны доод төгсгөлийн 1/3-ийн цусан хангамжийг хэвийн явуулна
- /30./ Дээд мөчний мэдрэл
- A. N.Axillaris-мөрний арын мултралын үед илүү тохиолдоно
 - B. Гэмтлийн үед судасны гэмтэл нь мөрний мэдрэлийн сүлжээг /Plexus brachialis/ бодвол элбэг тохиолдоно.
 - C. N.Radialis нь шууны 2 ясны хугарлын үед илүү гэмтэнэ
 - D. Атгаал ясны доод хэсэгт ил аргаар остеосинтез хийх үед N.Ulnaris-ыг хамгаалсан байх ёсгүй
 - E. Шуу ясны доод хэсгийн хугарлын үед N.Medianus гэмтэх нь ховор
- /31./ Түнхний үений гаж хөгжил /дисплази/ эрт үед хийгдэх эмчилгээ
- A. Эвийн
 - B. Гөлтгөнөн боолт
 - C. Үйл ажиллагааны чигүүд
 - D. Мэс заслын
 - E. Аль нь ч болно
- /32./ Олон хавирганы хугарлын үед хийх хэсгийн өвчин намдаагч бэлдмэлээр хориг хийх
- A. Хугарлын үзүүрүүдийн хооронд
 - B. Паранефральнай
 - C. Школьниковын хориг
 - D. Хугарсан хавирганы мэдрэлийн ёзоорт
 - E. Цээжний ханыг мэдээгүйжүүлэх хориг
- /33./ Дунд чөмөгний хүзүү хугарсан үед хийх үндсэн эмчилгээг нэрлэ.
- A. Мэс засал
 - B. Ясны татлага
 - C. Гөлтгөнө боолт
 - D. Бариа засал

Е. Зөөлөн татлага

/34./ Майга тавхайд хэдэн настайгаас мэс заслын эмчилгээ эхлэх вэ?

- A. 6 сар
- B. 12 сар
- C. 1 нас
- D. 5 нас
- E. 7-10 нас

/35./ Гол тэжээгч тараагуур судасны гэмтсэн үеийн эрт үеийн сонгомол шинжүүд:

A. Судасны түвшинд шарх үүссэн байх биеийн температур өгсөх, цус алдах, цусны цагаа бөөм ихсэх, гэмтсэн хэсэгт хавдах, гэмтсэн хэсгийн захад цус багадалт.

B. Судасны түвшинд шарх үүссэн цус алдалт, гэмтсэн хэсэгт хавдсан, захын хэсэгт цус багадалт илрэх

C. Шарх үүссэн, цус алдах, судасны шуугиан

D. Биеийн температур ихсэх, шарх үүссэн, цагаан бөөм олшрох, цус алдах

E. Гэмтсэн хэсэгт хавдах, шархтай захын хэсэгт цус багадах, судасны шуугиан гарах.

/36./ Роландын хугарал ямар ясан дээр үүсэх вэ?

- A. Атгаал яс
- B. богтос яс
- C. шуу яс
- D. сарвуу яс
- E. шилбэ яс

/37./ Түлэнхийн шархыг хэдэн зэрэг болгож хуваадаг вэ?

- A. I, II, III-A, III-B, IV
- B. I, II
- C. I-A, II-B
- D. I, II, III, IV-A, IV-B, V
- E. I, II, III-A, III-B

Сонгогдсон сорил-4/

/38./ Химийн түлэгдэл авсан улаан хоолой, ходоодонд гуурс тавих нь:

- A. Заавал тавина.
- B. Тодорхой хугацааны дараа тавина.
- C. Зөвхөн хүчилд түлэгдвэл тавина.
- D. Зөвхөн шүлтэнд түлэгдвэл тавина.
- E. Гуурставихыгхориглоно.

/39./ Уушигны хатгааны зонхилон тохиолдох эмнэл зүй – морфлогийн хэлбэрийг тодорхойл

- A. Уушигны цусан хатгалгаа
- B. Голомтот хатгалгаа
- C. Завсарын уушигны хатгалгаа
- D. Вирус – халдварын хатгалгаа
- E. Мөөгөнцөрт уушигны хатгалгаа

/40./ Хордлогот бахлуур үүсэх эх сурвалж:

- A. Халдварын
- B. Харшлын
- C. Аутоиммуны
- D. Дархлааны
- E. Мэдрэл-сэтгэл зүйн

/41./ Улаан хоолойн өргөссөн хураагуур судсаас цус алдах үеийн оношлогооны хамгийн оновчтой арга аль нь вэ?

- A. Бари уулгаж рентгенд харах
- B. Улаан хоолой дурандах
- C. Целиакус судсаар ангиографи хийх

- D. Улаан хоолойд баллонт тампон тавих
 - E. Дэлүүний эдэд манометри хийх
- /42./ Гурван хавтаст хавхлагын нарийслийн гэрлийн шинж нь:
- A. Зүүн ховдол томорно
 - B. Зүүн тосгуур томорно
 - C. Баруун тосгуур томорно
 - D. Баруун ховдол томорно
 - E. Ховдол, тосгуурууд томорно
- /43./ Элэгний шархнаас ихээр цус алдахад ямар хагалгааг хийх нь тохиромжтой вэ?
- A. Шархыг оёх
 - B. Шарханд чихээсхийх
 - C. Шархыг өргөсгөж, судсыг боох
 - D. Элэгний өөрийнх нь артерийн судсыгбоох
 - E. Элэгний гэмтсэн хэсгийгтайрах
- /44./ 18-25 насны өвчтөн 12 хуруу гэдэсний шархтай. Шарх нь 2 см-ээс илүүгүй хэмжээний нэвчтэстэй тэр нь цоороод 6 цаг орчим болжээ. Ямар мэс засал хийж болох вэ?
- A. Шархны ирмэгийг зүсч аваад оёх
 - B. Тэнэмэл мэдрэлийг таслах, шархны ирмэгийг зүсч аван нугалуурыг нөхөн сэргээх
 - C. Ходоодыг анхдагчаар тайрах
 - D. Опель-Поликарповын аргаар цоорсон нүхийг оёх
 - E. Ходоодны гарах хэсгийг 12 хуруу гэдэсний хамт тайрах
- /45./ Зүүн ховдолд агшилтын даралт өндөр болох нь аль тохиолдолд вэ?
- A. 2 хавтаст хавхлагын дутагдал
 - B. Гол судасны хавхлагын нарийсал
 - C. 2 хавтаст хавхлагын нарийсал
 - D. Гол судасны хавхлагын дутагдал
 - E. 2 хавтаст ба гол судасны хавхлагын нарийсал
- /46./ Цээжний гялтангийн үрэвслийг зонхилон үүсгэдэг шалтгааныг заана уу.
- A. А Гаднаасхалдвар орох
 - B. Цус - буюу тунгалагийн халдвар
 - C. Үжлийн халдвар
 - D. Зэргэлдээ эрхтэнээс халдвар дамжих
 - E. Мөгөөрсөн хоолойгоорхалдвар орох
- /47./ Хошногоны хуниас булчинтай харьцаж байгаагаар нь параректаль цоргыг ангилахад аль нь орох вэ?
- A. Хуниасны ирмэгээр
 - B. . Хуниасны алсуур
 - C. Хуниасны захаар
 - D. Хуниасны төвөөр
 - E. Хуниасны дундуур
- /48./ 12 хуруу гэдэсний хүндрээгүй шархлаанд аль мэс заслыг хийх вэ?
- A. Селективная проксимальная ваготомия+пилоропластик
 - B. Селективная проксимальная ваготомия+шархыг өөлж авах
 - C. Шархыг өөлж, столовая ваготомия
 - D. 12 хуруу гэдсийг тайрах
 - E. Селективная проксимальная ваготомия
- /49./ Холедохоеюно залгаас найдлагатай сайн болоогүй гэж үзвэлдекомпрессийн гуурсыг яаж тавих вэ?
- A. . Цөсний хүүдийн тайрагдсан цоргоор
 - B. Холедоход Т хэлбэрийн гоожуурга тавих

- C. . Ру-гээр авсан гэдэсний үзүүрээр
- D. Спасокукоцкийн гуурсаар
- E. Вишневскийн аргаар

/50./ Барийг 12 хуруу гэдэс рүү шууд хаймсуурын тусламжтай оруулахад хэвийн үед хэдэн цагийн дараа мухар гэдсэнд хүрэх вэ?

- A. 1.5 цаг хүртэл
- B. 2.5-2 цаг хүртэл
- C. 3-4 цаг
- D. 5-6 цаг
- E. 7-8 цаг

/51./ Рентген шинжилгээгээр илрэх мөгөөрсөн хоолой тэлэгдлийн шинжийг заана уу.

- A. Уушигны голомтот сүүдэржилт илрэх
- B. Уушигны угийн бүтэц өргөсөх
- C. Уушигт мөгөөрсөн хоолойн тэлэгдлүүд
- D. Өрцний хөдөлгөөн хязгаарлагдах
- E. Уушигны захын хэсгүүд шалчийх

/52./ Улаан хоолойн нүхээр үүссэн ивэрхийн илрэх шинжийг заана уу.

- A. Өвчүүний араар өвдөх + аюулхайд өвдөх + хахаж цацах
- B. Өвчүүний араар өвдөх + хахаж цацах + зүрх хурдан цохилох
- C. Өвчүүний араар өвдөх + хахаж цацах + бөөлжих
- D. Хахаж цацах + хэвтээ байрлалд биеийн байдал муудах + цээжхорсох
- E. Аюулхайд өвдөх+ зүрх хурдан цохилох + бронхит

/53./ Гэнэт цээжний хөндийд дотроосоо хий хурах шалтгаан

- A. Аюулгүй
- B. Амиа алдах магадлал 10% хүртэл
- C. Амиа алдах магадлал 25% хүртэл
- D. Амиа алдах магадлал 50% хүртэл
- E. Амиа алдах магадлал 100% хүртэл

/54./ Фиброколоноскопи болон ректороманоскопийн шинжилгээний үед бүдүүн гэдэсний салст бүрхүүлд ялзрах, хавагнах, цус шүүрэлт илэрдэг өвчнийг нэрлэнэ үү?

- A. Кроны өвчин
- B. Цусан суулга
- C. Бүдүүн гэдэсний шархлаат үрэвсэл
- D. Бүдүүн гэдэсний сүрьеэ
- E. Лимфогрануломатоз

/55./ 26 настай эмэгтэйд бамбай булчирхай нь томорсон. Пункци хийж эдийн шинжилгээ авахад эдээс нь амилloyd илэрсэн. Бамбай булчирхай томорсон талын хүзүүний тунгалгийн булчирхайнууд тэмтрэгдэхүйц болсон. Уг өвчтөнд эмчилгээний зөв тактикийг сонго.

A. Бамбай томорсон зангилааг бүлтэлж, хүзүүвчийн хамт авч томорсон тунгалгийн булчирхайг түүх

B. Бамбайн томорсон зангилаа, хүзүүвч, эрүүл талын хагасыг авч томорсон тунгалгийн булчирхайг түүх

C. Бамбайн томорсон зангилаа, хүзүүвчийг авч хүзүүний тунгалгийн булчирхай томорсон талын бүх булчирхайг шулж авах

D. Бамбай булчирхайг бүхэлд нь авч, тунгалгийн булчирхай томорсон талын хүзүүний тунгалгийн булчирхайнуудыг шулж авах

E. Бамбай булчирхайг авч, тунгалгийн булчирхайг үлдээх

/56./ Цөсний хурц үрэвслийн улмаас цөс нь хагарч, хэвлийн хөндий руу тарсан үед аль шинж нь илрэх вэ?

- A. Арьс салст шарлаж, элэгтоморч өвчтөн сепсисийн байдалд шилжих
 B. Хэвлийн гялтангийн түгээмэл үрэвсэл
 C. Хэвлийн баруун сүврэгдэсийн булчин чангаран, халуун нэмэгдэхгүй цесний хүүдий тэмтрэгдэнэ.
 D. Баруун хавирган доорх хэсгийн гялтангийн үрэвслийн шинж илэрнэ.
 E. Хоёрдогч холангит, панкреатит, мөханик шарлалт илрэх
- /57./ Рефлюкс эзофагитийн үед доорх шинжүүдээс аль нь илрэхгүй вэ?
 A. Горойлт
 B. Цээж гашуу оргих
 C. Гашуунаар хэхрэх
 D. Бөөлжилт
 E. Өвчүүний ард горойж өвдөх
- /58./ Хураагуур судасны бүлэнт үрэвслийн дараах хам шинжийн үед ямар шинж илрэх вэ?
 A. Арьсан дээр хөх тууралт үүсэх
 B. Хөлийн шилбээр хавагнах
 C. Арьсан доорх хураагуур нарийсах
 D. Арьсны өнгө өөрчлөгдөхгүй цоорох
 E. Арьсан дээр шархлаа үүсэхгүй
- /59./ Улаан хоолойн нарийсалт гэдэг нь:
 A. Голч нь 1/3-ээс ихээр багасах
 B. Голч нь 1/4-ээс ихээр багасах
 C. . Голч нь 1/2-оос ихээр багасах
- /60./ Хүзүүний орчимд улаан хоолойг гадагшлуулах оновчтой газрыг- заана уу.
 A. Мөгөөрсөн хоолойноос зүүн тийш + өвчүү эгэм хөхөлбөрийн булчингийн урдуур
 B. Мөгөөрсөн хоолойноос баруун тийш + өвчүү эгэм хөхөлбөрийн булчингийн урдуур
 C. Мөгөөрсөн хоолойн баруун тийш + өвчүү эгэм хөхөлбөрийн булчингийн хойгуур
- /61./ Хэвлийн гэдэс хоорондын наалдаст өвчнийг оношлох шинжилгээний үндсэн арга нь аль вэ?
 A. Хэвлийг гэрэлд тойм харах
 B. Гэдэс ходоодны замаар пассаж үзэх
 C. Эзофагогастродуоденоскопи
 D. Прозерины сорил хийх
 E. Хэвлий дурандах / лапароскопи /
- /62./ Гол судас ба хоёр хавтаст хавхлагын нарийслын үед баруун урд ташуу байрлалд бариулган улаан хоолойг харахад хэрхэн хазайх вэ?
 A. Бага радиусын нумаар
 B. Их радиусын нумаар
 C. Улаан хоолой нь хазайхгүй
- /63./ Элэгний бэтэгний үед хагалгаа хийх тохиромжтой хэмжээг заана уу.
 A. Уйланхайг бүлтлэн авах/эпуклеаци/
 B. Далд аргаар бэтгийг авах
 C. Уйланхайг ялгаж огтлох-элгийг тайрч үйл анхайтай хамт авах
 D. Уйланхайг нээж аваад хальсыг үлдээх
 E. Уйланхайг нээж, үлдэгдэл хөндийг устгах
- /64./ Ямар эмчилгээнээс бусдыг нь спонтанный пневмоторакс-д хэрэглэх вэ?
 A. Уушиг оёх
 B. Торакоцентез
 C. Торакопластик
 D. Плеврийн хатгалт хийх

Е. Уушигны сегмент авах

/65./ 2 хавтаст хавхлагын дутагдлын нөхөн сэргээх хагалгааг дараахаас бусад үед хийж болно

- А. Фиброз цагирагийн дилатаци
- В. Өмнөд хавтасны 2/3 –с илүү хордын урагдал
- С. Хордын утас уртсах
- Д. Өмнөд хавтасны нэг хордын урагдал
- Е. Нэг хавтас нь байхгүй байх

/66./ Цээжний баруун ар талаас нээхэд харагдах уушигны угийн эрхтэнүүдийн байрлалын дарааллыг заа

А. Мөгөөрсөн хоолой – уушигны тараагуур судас + уушигны дээд хураагуур судас + уушигны доод хураагуур судас

В. уушигны тараагуур судас - Мөгөөрсөн хоолой + уушигны доод хураагуур судас + уушигны дээд хураагуур судас

С. уушигны доод хураагуур судас – уушигны дээд хураагуур судас +Мөгөөрсөн хоолой уушигны тараагуур судас

Д. уушигны доод хураагуур судас – уушигны дээд хураагуур судас +уушигны тараагуур судас + Мөгөөрсөн хоолой

Е. Уушигны доод хураагуур - уушигны дээд хураагуур судас + уушигны тараагуур судас+мөгөөрсөн хоолой

/67./ Шамбарам үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл юу вэ?

- А. Хэвлийн дотоод даралт ихдэх
- В. Удаан гуйлгэх
- С. Өтгөнөө тасалж гаргах
- Д. Хэвлийн эрхтэний өвчнүүд
- Е. Удаан явган явах

/68./ 12 хуруу гэдэсний шархлаа зонхилон цоорох байрлал нь аль вэ?

- А. Урд хана
- В. Урд-дээд хана
- С. Арын хана
- Д. Арын доод хана
- Е. Арын дээд хана

/69./ Холедохоеюноанастомоз нь бусад залгааснаас давуу талтай нь:

- А. Рефлюксхолвнгит үүсдэггүй.
- В. Дээрх гэдэс татагдах, деформац болохгүй
- С. Гэдэс ходоодны зам хангалттай тусгаарлагдана.
- Д. Залгаасны нүх нарийсана.
- Е. Хэвлийд наалдац үүсэх магадлалтай.

/70./ Сүрьеэгийн гаралтай хэвлийн гялтангийн үрэвслийн үед аль хэлбэр нь гэдэсний цоорхой үүсгэх вэ?

- А. Шүүдэст хэлбэр
- В. Наалдаст хэлбэр
- С. Нэвчдэст
- Д. Олон зангилаатхэлбэр
- Е. Хавсарсан хэлбэр

/71./ Хүндэрсэн мөгөөрсөн хоолойн тэлэгдлийн эмнэл зүйн шинж аль вэ?

- А. Өвчин тогтмол хурцдах + хөөсөрхөг цэр гарах
- В. Өвчин тогтмол хурцдах + идээт цэр гарах
- С. Өвчин тогтмол хурцдах + биеийн ачааллын үед амьсгаадах
- Д. Өвчин тогтмол хурцдах + идээт хордлого
- Е. Өвчин тогтмол хурцдах + уушгинд зогсонги илрэх

/72./ Улаан хоолойн нүхээр зонхилон ямар эрхтэн ивэрдэг вэ?

- A. Ходоодны ёроол хэсэг
- B. Ходоодны дээд амсар
- C. Том сэмж
- D. Нарийн гэдэс
- E. Бүдүүн гэдэс

/73./ Мөгөөрсөн хоолой тэлэгдэлд уушиг тайрах хэмжээг тодорхойлох үндсэн хэмжүүр юу болох вэ?

- A. Гадаад амьсралын нөөц
- B. Клиникийн үндсэн шинжийн өгөгдөл
- C. Тодотгогч бодистой хийсэн гуурсан хоолойн зургийн өгөгдөл
- D. Мэс заслын үед уушигны байдлыг тодорхойлох
- E. Рентген шинжилгээний өгөгдөл

/74./ Бүдүүн гэдэсний баруун хэсгийг цусаар хангах судас нь аль вэ?

- A. Дээд чацархайн тараагуур судас
- B. Доод чацархайг тараагуур судас
- C. Ташааны дотуур баруун тараагуур судас
- D. Ташааны дотуур зүүн тараагуур судас
- E. Гэдэсний гол судас

/75./ Уурагт бодис хоол боловсруулах замд хаана ямар ферментээр боловсорч эхлэхвэ?

- A. Амны хөндийд амилазаар
- B. Ходоодонд пепсинээр
- C. 12 нугалаа гэдсэнд трипсинээр
- D. Бүдүүн гэдсэнд химотрипсинээр
- E. Нойр булчирхайн ферментүүдээр

/76./ Эрүүл хүний цусан дахь ферментийн бүтэц яаж өөрчлөгддөг вэ?

- A. Байнга ихсэх
- B. Байнга багасах
- C. Ихсэж багасах нь ээлжилнэ
- D. Тогтмол байна
- E. Алгуур хувирдаг

/77./ Бие махбодид липидын задралыг хүчтэй болгож, нүүрс ус - өөх тос болох үйл явцыг саатуулагч даавруудыг заана уу ?

- A. Андроген, эстероген
- B. Липотропин, аденозин
- C. Тиреотропин, меланотропин
- D. Инсулин, глюкагон
- E. Адrenокорткотропин, самототропин

/78./ Менингококкийн шинжийг дурдана уу?

- A. Мушгиа хэлбэртэй
- B. Зууван хэлбэртэй
- C. Гинж үүсгэсэн байрлалтай
- D. Хос кокк
- E. Савханцар хэлбэртэй

/79./ Нүүрс ус организмд шаардлагатай энергийн хэдэн хувийг үүсгэх вэ ?

- A. 60%
- B. 50%
- C. 40%
- D. 30%
- E. 20%-оос доош

/80./ А витамин дутагдахад ямар ерөнхий шинж ажиглагдах вэ ?

- A. Арьс гуужих, харанхуйд нүд дасахгүй болох
- B. Өсөлт зогсох, цус гоожимтгой болох
- C. Цус багадах, нүд аргах
- D. Өсөлт удаашрах, нүд хуурайших

/81./ Эрүүл хүний цусны биохимийн шинжилгээний ALAT / ГПТ/ ферментийн лавлах хэмжээг заана уу ?

- A. 0,5 – 1,0 мкмоль/л 5 – 42 U/L
- B. 0,4 – 0,90 мкмоль/л 40 – 215 U/L
- C. 0,1 – 0,8 мкмоль/л 28 – 190 U/L
- D. 0,1 – 0,75 мкмоль/л 28 – 127 U/L
- E. 0,2 – 0,80 мкмоль/л 30 – 200 U/L

/82./ Лейкоцитын тоо $6,3 \times 10^9$ /л, лимфоцит 22% бол лимфоцитын бодит тоо хэд байх вэ?

- A. 1,38%
- B. 1,56%
- C. 1,41%
- D. 2,02%
- E. 1,92%

/83./ Numareader багаж нь шинжилгээг хэдэн төрлийн аргаар хийдэг вэ?

- A. Гурав
- B. Тав
- C. Долоо
- D. Ес
- E. Арван хоёр

/84./ Нэг грамм өөх тос бүрэн исэлдэхэд хичнээн энерги ялгарах вэ ?

- A. 17,15 кдж / 4,1 ккал/
- B. 25,50 кдж / 6,5 ккал/
- C. 34,30 кдж / 8,2 ккал/
- D. 38,90 кдж / 9,3 ккал/
- E. 45,50 кдж / 18,2 ккал/

/85./ Уургийн коллоид уусмалын хамгийн жижиг хэсгийн хэмжээ ямар байх вэ?

- A. 0,1 нм
- B. 1 нм-1 мкм
- C. 1 нм
- D. 1 мкм
- E. 1 мкм-2 мкм

/86./ Эритроцитын хөгжлийн үе шатыг заана уу?

- A. Миелобласт-промиелоцит- миелоцит- метамиелоцит- савхан бөөмт эс
- B. Эритробласт-промегакариоцит- мегакариоцит- ретикулоцит
- C. Эритробласт-пронормоцит-нормоцит базофильный-нормоцит полихроматофильный-нормоцит оксифильный- ретикулоцит
- D. Эритробласт-пронормоцит- нормоцит полихроматофильный- нормоцит оксифильный- ретикулоцит

- E. Мегакариобласт-промегакариоцит, мегакариоцит

/87./ Гахай хавдар өвчний эсрэг эсрэг бие илрүүлэх ELISA/ФХУ-ын шинжилгээнд дараахи сорьцыг ашигладаг

- A. хоолойн арчдас
- B. ийлдэс

- C. шээс
 - D. өтгөн
 - E. Шүлсний булчирхайн цоргоноос арчдас авна
- /88./ Нуклеопротейдын уургийн хэсэг юунаас тогтох вэ ?
- A. Зөвхөн протамин
 - B. Зөвхөн гистон
 - C. Зөвхөн урацил
 - D. Протамин болон гистон
 - E. Урацил болон гистон
- /89./ Өөхний дээд хүчлийн исэлдэлт хаана явагдах вэ ?
- A. Эсийн цитоплазмд
 - B. Митохондрид
 - C. Гэдэсний салстын хучуур эдэд
 - D. Гольджийн торлогт
 - E. Эсийн микросомд
- /90./ Соматотропин дааврын илүүдэл ялгарлаас үүссэн эмгэгийг заана уу?
- A. Акромегали
 - B. Гипофизийн гигантизм
 - C. Гипогонадизм
 - D. Креатинизм
- /91./ Ферментийн өвөрмөц чанар гэдэг нь:
- A. Зөвхөн нэг бүлэг бодисд үйлчлэх чанар
 - B. Нэг бүлэгт багтдаг олон янзын бодисд үйлчлэх
 - C. Ямар нэг изомерт үйлчлэх чанар
 - D. Нэг фермент тодорхой нэг бодис буюу химийн холбоонд үйлчлэх
- /92./ Ямар эмгэгийн үед цэрэнд бортгон эпители ихээр илрэх вэ?
- A. Хурц бронхит
 - B. Цусан хатгалгаа
 - C. Бронхэктази
 - D. Уушигны буглаа
 - E. Бронхийн багтраа
- /93./ Ферментийн саатуулагч гэж юуг хэлэх вэ ?
- A. Субстрат
 - B. Хурд нэмэгдүүлэгч
 - C. Ферментийн үйлчилгээг арилгах эсвэл, ферментэн урвалын хурдыгбууруулах бодисыг
 - D. Урвалын энергийн хаалтыг
 - E. Фермент
- /94./ Ялтас эсийн адгези гэж ямар үзэгдлийг нэрлэх вэ?
- A. Ялтас эс олширох
 - B. Ялтас эс цөөрөх
 - C. Судас гэмтсэн хэсэгт ялтас эс наалдах
 - D. Судас агшиж нарийсах
 - E. Ялтас эс бөөгнөрөн агшиж нягтрах
- /95./ Эозинофил ямар өвчний үед өтгөнд илрэх вэ?
- A. Колит
 - B. Амебиаз
 - C. Шимэгч хорхойтох
 - D. Энтерит
 - E. Гастрит
- /96./ Организмд уураг ямар төлөвт байдаг вэ?
- A. Зөвхөн хатуу

- B. Зөвхөн шингэн
- C. Хатуу ба шингэн
- D. Коллоид уусмал
- E. Иончлогдсон

/97./ Заг хүйтэн үүсгэгчийг нэрлэ

- A. Chlamydia trachomatis
- B. Neisseria gonorrhoeae
- C. Candida albicans
- D. Mycoplasma
- E. HPV 16,18

/98./ Амьд организмын жингийн хэдэн хувийг нүүрс ус эзлэх вэ ?

- A. 70-80%
- B. 40-70%
- C. 20-40%
- D. 5-10%
- E. 2%

/99./ Хүнсний өөх тос хаана, хэрхэн цийдмэгжиж жижиглэгдэх вэ ?

- A. Амны хөндийн шүлсний оролцоотой
- B. Ходоодонд давсны хүчлийн нөлөөгөөр
- C. 12 нугалаа гэдсэнд цөсний оролцоотой
- D. Цөсний замд билирубины нөлөөгөөр
- E. Бүдүүн гэдсэнд бичил биетний тусламжтай

/100./ Эрүүл хүний цусны биохимийн шинжилгээний ASAT / GOT/ ферментийн лавлах хэмжээг заана уу ?

- A. 0,1 – 0,75 мкмоль/л 7 – 37 U/L
- B. 1,2 – 0,80 мкмоль/л 30 – 200 U/L
- C. 0,3 – 0,85 мкмоль/л 35 – 210 U/L
- D. 0,4 – 0,90 мкмоль/л 45 – 220 U/L